

ХІІІ ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛ, ФРАНЦЫН ХАРИЛЦАА

Л.Оюунгэрэл

Монголын нэгдсэн төр улс байгуулагдаж улмаар эзэнт гүрэн болж өргөжин тэлэх үеэс эхлэн Европынхон Чингис хаан, монголчуудын талаар анхны мэдээ сэлтийг сонсох болжээ. 1219 онд Чингис хааны цэрэг Хорезмыг дайлахаар мордож улмаар бутцохисон нь Францын хаан, шашны дээдчүүлд, ер нь Европ даяар асар их итгэл найдвар төрүүлж байв. Учир нь Европынхон тэр үед лалын эсрэг загалмайтны дайн хийж байсан ба Хорезмын хаант улс бол лалын шашныг албан есны бодлогоо болгон тунхагласан хоёр дахь том төвлөрсөн улс байсан билээ. (Эхнийх нь Арабын хаант улс; гуравдахь нь Багдадын халифат)

1221 онд загалмайтны цэрэг Египет, Дамаскийн султан хаадад Дамьетта боомтонд бутцохигдож ихээхэн хохирол амсаж байсан тэр үед Жак де Витри хэмээх Птоломейн лам Ромын пап Хонорьус III, Парисын Их Сургуульд илгээлт илгээж 'Дэвид хэмээх Христын хаан Хорезмын хааныг унагаж Персийг бараг эзэлж одоо Багдадаас тав хоногийн зайд байлдаж байна' гэж бичиж байв. (1) Энэ бол тухайн үедээ Францын хаан ер нь Европынхонд Чингисийн байлдан дагуулалтын талаар хүрсэн анхны тодорхой мэдээ байсан билээ. Энэ мэтээр Монголын тухай мэдээлэл янз бүрийн шугамаар хүрч байжээ; Монголчуудад эзлэгдсэн улс орны тэргүүн нар, жишээлбэл Гүржийн хатан хаан Руссудан, Унгарын Бела, Арменийн хаад Европынхонд бичгээр ба амаар хандаж байжээ.

Дундад зууны үеийн нэрт түүхч Парисын Мэтье (2) Монголчуудын байлдан дагуулалтын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж Европын хаад, шашны тэргүүн нарт танилцуулж байв. Түүнчилэн загалмайн цэргүүдийн байлдаж явсан улс орнууд, монголчууд ба францчуудтай аль алинтай нь ойр харилцаж байсан Армени, Сирид байсан христын лам нар Монголын талаар мэдээлж байжээ.

Гэтэл монголчуудын байлдаж явсан нутаг орноос улам бүр түгшүүртэй мэдээ ирэх болжээ. 1237 онд Мухаммедын элч эзэн хаан Фредерикт хандаж Монголчуудын эсрэг тусламж үзүүлэхийг хүсчээ. (Энэ үед Өгэдэй хааны зарлигаар Чормаган, Байжу нар гурван түмэн цэрэгтэй Персэд байлдаж байсан) Улмаар Франц, Английн хаадад бас ханджээ. (3) 1240 онд Унгарын Бела хаан бас тусламж хүсч тэдэнт хандав. Энэ үеэс Өрнөд Европынхон Монголын талаар тодорхой

бодлого боловсруулж баримтлах хэрэгтэй болжээ. Харин тэр үед Европод нөлөө бүхий Ромын пап, Ромын эзэн хаан Фредерик II, Францын Луи IX нарын Монголын талаар баримталж байсан бодлого өөр хоорондоо бас ялгаатай байжээ. Фредерик II Монголчуудын эсрэг загалмайн дайн хийх талыг илүү баримталж байсан бөгөөд 1241 онд Европын хаадад шаардах бичиг илгээж Монголчуудын аюул занал Европыг немерч байгаа тухай дурьдаад нийтийн хамгаалалтын үйлсэд хаан бүр тодорхой хэмжээний хүн хүч, зэр зэвсэг нийлүүлэхийг хүсэж байв. Харин Ромын пап Иннокентий IV ба Францын Луи IX хаан ойролцоо байр суурьтай байсан ба Монголын талаар илүү аядуу байр суурь баримталж судалж тандах, Монголын хаадын шашны үзлийг таньж мэдэх, болж өгвөл Христын шашинд итгүүлэх хүсэл эрмэлзэлтэй байжээ. Германы ноёд Херфорд хотод, христын шашны лам нар Мерсебург-д цугларч монголчуудын эсрэг хүчээ нэгтгэн Загалмайн дайн хийх тухай ярьж байсан ч өөр хоорондоо зөрчилтэй байсан зэрэг шалтгаанаар Унгарт туслаагүй өнгөрсөн билээ. Европын хаад өөр өөр улсыг монголчуудаас хамгаалах асуудлаар илүүтэй түгшиж байжээ.

Харин монголчууд өөрсдөө Европд эхэлсэн байлдан дагуулалтаа зогсоосон билээ. Гэвч тэднийг эргэж ирнэ гэсэн айдас байсаар байжээ. Монголчууд дэлхийг эзлэх хүсэл эрмэлзэлтэй гэж Европын хаад, христын сүм үзэж байв. Тийм ч учраас Европд дахин эргэж ирэх эсэхийг мэдэхийг хүсэж байсан бөгөөд тэднийг христын шашинд дагуулах талаар санаа сэдэх болжээ.

1245 онд Ромын пап Иннокентий IV Францын Лион хотод шашны Ерөнхий Зөвлөлийг хуралдуулж Монголын аюулын талаар хэлэлцэн ярилцжээ. Папын саналаар элч илгээх болж нэгийг нь Хархорин (Плано Карпини), нөгөөг нь Перс (Асцелин-Байжу ноентой уулзсан) рүү явуулжээ. Плано Карпинийн айлчлал, Ромын папын захидлын хариуд Гүюг хааны илгээсэн захидлын талаар Европын бүх хаад, түүний дотор Францын Луи IX хаан сайн мэдэж байсан нь тодорхой.

Папын 1245 оны 3 сарын 13-ны захидалд Христын шашинтан ба бусал орнуудын эсрэг довтлон сүйтгэж байгааг нь эсэргүүцэж, христын шашинтныг үй олноор нь бүрэлгэн сүйтгэхээ даруй зогсоохыг хатуу шаарджээ. Үүний хамтад пап ламтан өөрийн бие төлөөлөгч, их номтны номлол, үгийг хүндэтгэн хүлээн авч зөвшилцөхийг хүсчээ. Энэ байр суурь ерөнхийдөө Өрнөдийнхний нийтлэг байр суурь байсан нь ойлгомжтой.

Гүюг хаанаас 1246 оны 11 сард Инносент IV папад илгээсэн захидлын утга агуулгыг гадаадын ихэнх түүхч 'сүрдүүлэн заналхийлсэн шинжтэй' гэж үзсээр ирсэн боловч түүнийг судлахад бас ч олон талын дүгнэлт хийж болмоор байгаа билээ. Юуны өмнө энэхүү захидал нь Монголын эзэнт гүрний бодлогыг бичгээр томьёолж тайлбарласан улс төрийн анхны баримт бичгүүдийн нэг юм. Уг захидалд (4): 'Унгар ба Христын шашинтан бусад улс орныг бүрэлгэн сүйтгэж байна' гэж зэмлэснийг нь 'үл ухаж байна' хэмээн няцааж, 'тэдгээр газарт элч илгээж Бурханы тушаалыг хүргүүлсэн боловч тушаалыг үл гүйцэтгэн элчийг хорлосон' гэж тайлбарлажээ. Монголын эзэнт гүрний сүр хүчийг 'Дээд Тэнгэрийн хүчин дор наран ургахуй газраас наран жаргахуй хүртэлх бүх улс орон' Монголын Хаанд захирагдсан болохыг дурьджээ. Захидалд Ромын пап элч илгээснийг харилцааны эхлэл гэж үзэж байгаа нь тод ажиглагдаж байгаа юм. Бид 'эдүүтээгээс эхлэн та бүхнийг ивээлдээ орсон хэмээн үзсүгэй' гэжээ. Гэхдээ 'биеэр' хүрэлцэн ирэх 'естойг тэмдэглэсэн ажээ. Улс хоорондын харилцаанд баримтлах гол зарчмаа - 'биеэр хүрэлцэн ирж Ясагийн (Их Засаг) тушаал бүрийг сонсогтун' гэж томьёолжээ.

Гүюг хааны тодорхойлсон чухам дээрх зарчмуудад үндэслэж монгол, францын элчийн харилцаа хөгжиж эхэлжээ. Хоёр улсын харилцааг үүсгэн хөгжүүлэхэд Гүюг, Мөнх хаан, Луи IX хаад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. 1248-1270-аад он хүртэл хорь гаруй жилийн хугацаанд хоёр орны харилцааны түүхэн үйл явдлууд нь (~ 1248 оны 12 сард Гүюг хаан Францын Луи IX хаанд нагац ах Илжигдэй ноеноор дамжуулж христын шашны талаар байр сууриа илэрхийлэв; ~ 1249 оны 2 сард Францын Луи хаан Гүюг хаанд Андрэ Лонжюмо хэмээх элчээр захидал, бэлэг илгээсэн; ~ Гүюгийн бэлбэсэн эхнэр, Монголын төрийн хэргийг түр хамаарч байсан Каймиш хатан Францын Луи IX хаанд захидал, бэлэг илгээсэн; ~ Францын Луи IX хааны элч Гийум Рубрук 1253 онд Хархоринд очиж хааны захидлыг гардуулсан, ~ Мөнх хаан Францын Луи IX хаанд Г.Рубрукээр захидал, бэлэг илгээсэн, ~ Г.Рубрук Монголд айлчилж Мөнх хаан, Бат хаан, түүний хүү Сартактай уулзаж ярилцсан, ~ Г.Рубрук айлчлалынхаа талаар ном бичиж хэвлүүлсэн) дундад зууны үед ховор байсан элчийн буюу энхийн харилцааны тод жишээ юм.

Элчийн харилцааны явцад Монгол, Францын хаад улс төрийн байр суурь, үзэл бодлоо харилцан мэдээлж хамтран ажиллах боломжуудаа судалж байжээ. Юуны өмнө 1. Хоёр улсын Өрнөд Ази

дахь байлдааны ажиллагааны явц, энэ бүс нутаг дахь лалын улс орнуудын эсрэг хамтран тэмцэх боломжууд; 2. Монголын хаад Христын шашинд хэрхэн ханддаг тухай асуудлууд анхаарлын төвд байжээ.

Монголын эзэнт гүрэн Францын хаант улстай харилцахдаа энх тайванч харилцаатай бусад улс орны нэгэн адил Чингисийн үеэс уламжлан ирсэн 'Алтан аргамжааны' бодлого, ес хүндэтгэлийг (5) баримталж байжээ. Францын Луи IX хаанаас Гүюг хаанд, Мөнх хаанаас Луи хаанд тус тус илгээсэн захидлууд нь дундад зууны үеийн монгол, францын харилцааны анхны чухал дипломат баримт бичгүүд байжээ.

Монгол, Франц улсууд Өрнөд Азид явуулж байсан тус тусын бодлого, байлдааны ажиллагааг сайн мэдэж байсан ба бие биеэ дэмжиж байв. 1242-1246 онд Багдадын калиф Монголчуудын эсрэг ариун дайн зарлаж үй олон монголчууд алагдсан тухай Рашид-ад Дин бичсэн байдаг. Үүний дараахан буюу 1248 онд Гүюг хаан Армены төрийн дээд тушаалтан Семрад-г хүлээн авч үүлзаад Сельжукийн Румын эсрэг түүнд туслахыг амлаж байв. Мөн оны 12 сард нагац ах Илжигдэйн элч нараар дамжуулж загалмайтны сүүлчийн аян дайныг удирдаж Египетийн эсрэг дайралтад бэлдэж Кипрт байсан Францын хаанд ялж дийлэхийг ерөөж байжээ. Илжигдэй өөрөө Өрнөд Азид Христынхныг чөлөөлж эвдэрч сүйдсэн сүм хийдийг шинээр барих болно гээд дайн хийж байгаа шалтгаанаа 'Эв эеийг сахиж худалдаа хөгжүүлэхийг эрмэлзэж байна' (6) гэж элч нараараа хэлүүлж байжээ.

1250-1251 онд Луи IX хааны удирдсан загалмайтны цэрэг Мансура-д бутцохигдсон ба '30 мянган франкууд алагдаж хаан өөрөө Палестинд

олзлогдож их хэмжээний төлөөс төлж байж чөлөөлөгдсөн тухай Рашид-Ад Дин бичиж байв. (7) Олзлогдсонхоо дараахан Луи хаан Г.Рубрукийг Монголд элчээр илгээж байсан нь монголчуудад их найдвар тавьж байсны илрэл болов уу? Лалын ертөнцэд монголчуудтай холбоотон болох бодит боломжийг Өрнөдийнхнөөс Францын Луи хаан хамгийн сайн ойлгож байсан гэлтэй.

Г.Рубрук 1253 онд Хархоринд очиж Луи хааны ихэд сонирхож байсан хоёр асуултанд: Өрнөд Ази дахь дайн байлдааны талаарх Монголчуудын цаашдын төлөвлөгөө, Монголын хаад Христын болон лалын шашинд хэрхэн ханддаг, тэдний зарим нь Христын шашинд орсон эсэх талаар тодорхой хариулт авч чадсан билээ. Г.Рубрук бол Луи хааныг загалмайн дайнд дагаж явсан ойр дотных нь хүн байсан байна.

Тэрээр аян замын тэмдэглэлдээ монголын хаад,цэргийн жанжнуудын тухай,дайн байлдааны урлаг,монголчууд нум сумаар хэрхэн харвадаг,түмэн,аравтын цэргийн зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй бичиж лалын эсрэг Өрнөд Ази дахь монголчуудын цаашдын төлөвлөгөөний талаар судалж танилцуулсан билээ.(8)Монголд эзлэгдсэн,христын шашинтай Гүрж,Армен монголчуудыг өрнөдийн улс орнуудтай ойртуулахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байжээ. Армены Хайтон хаан Азийн загалмайтны холбоо байгуулахыг эрмэлзэж байсан ба үүнийг нь Францын Луи IX хаан дэмжиж байв.

Монгол,францын элчийн харилцааны явцад түүхэнд анх удаа тодорч гарч ирсэн нэг сонирхолтой асуудал бол Монголын хаадын ер нь монголчуудын шашин шүтлэгийн асуудал байлаа. Тэр үед Өрнөдийнхөн Гүюг ба Сартакыг христын шашинд орсон гэж дуулсан байжээ.Ер нь монголчууд аль ч шашинг ялгаварлан гадуурхдаггүй, харин өөрсдөө бол бөө шүтдэг гэдгийг Мөнх хаан Г.Рубрукт тайлбарлан ярьсан байдаг. Ийнхүү монгол,францын элчийн харилцааны үр дүнд Монголын хаад төрөл бүрийн шашин буюу оюун санааны үйл ажиллагааг шимтэн сонирхдог,улмаар бүр зарим нь христын шашинд талтай ханддаг байсан,эмэгтэй хүний оюун санааны чөлөөт байдлыг хүндэлдэг,(Гүюг хааны эхнэр христын шашинтай,бас Илхаадын заримынх нь эхнэр,хүүхэд мөн христын шашинтай байсан) шашин шүтлэг ба цэрэг, худалдааны хэргийг хооронд нь хольж хутгадаггүй зэрэг монголчуудын ертөнцийг үзэх үзлийн өвөрмөц онцлогууд түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн билээ.

Мөнх хааныг нас барснаас хойш монгол,францын элчийн харилцаа нь Монголын Илхаадын хоорондын хэлхээ,холбоогоор тодорхойлогдож байв. Илхаад нь христын шашинт Армен,Гүржид түшиглэн Ром, Францтай холбоотон болохыг эрмэлзэж байжээ.Ил хаан Хүлэгү Египетийн Мамлюкийн эсрэг холбоог 'бурхны шарилыг чөлөөлөх'гэдэг нэрийн дор байгуулахыг оролдож Ромын паптай элч солилцож байжээ.(9)Тэрээр Их хаадын Өрнөд Азийн талаар баримтлах бодлогыг тууштай үргэлжлүүлж байжээ. Түүнд монгол цэргийн зарчмаар зохион байгуулсан мамлюкууд сөрөн зогсож байв. Египетийн мамлюк султан Кутуз цэргээ биеэр удирдан Палестины нутаг руу ирж франкаас нутаг дундуур нь дайрч өнгөрөх зөвшөөрөл гуйжээ.Чухам түүхэн энэ агшинд өнө эртнээс яригдсан монгол,францын хоорондын холбоотны харилцаа тогтох эсэх нь шийдвэрлэгдэх учиртай байжээ.Гэвч тухайн үеийн тодорхой нөхцөл байдал; монголын харуулын анги болон Сидоны

Франк барон Юлианы хооронд орон нутгийн чанартай мөргөлдөөн болж Хит-Бухын ач хүү алагдсан, улмаар Франкууд Египетийн Кутузын цэргийг нутаг дээгүүрээ явж өнгөрөхийг зөвшөөрсөн зэрэг нь холбоотон болох замыг хаасан билээ. Мамлюкийн давуу хүчтэй цэрэг Хит Бухыг Айн Жалутэд 1260 онд бутцохив. Айн Жалутын тулалдаан бол ертөнцийн түүхэнд эргэлтийн үе байлаа гэж английн түүхч Ж.Саундерс бичсэн билээ. Ийнхүү олон жил яригдсан монгол, францын цэргийн хамтын ажиллагаа үндсэндээ бүтэлгүй болсон билээ. Үүнд тухайн үеийн олон улсын нөхцөл байдал хүчтэй нөлөөлжээ. Тухайлбал Египет, Алтан ордны улс, Сицилийн улс төр, эдийн засгийн ашиг сонирхол хэрэгжиж эхэлсэн, Хархорины гадаад бодлого, үйл ажиллагаа бүрхэг болсон, Хубилай хаан Хятадад хаан сууж Ромын пап, Өрнөдийнхөнтэй харилцаж байсан ч худалдааны эрх ашиг нь Чингис ба түүнийг залгамжлагчдынхаас өөр болсон зэрэг олон улсын нөхцөл байдлыг дурьдаж болно.

Гэхдээ л Илхаад Өрнөдтэй хамтран ажиллах бодлогоосоо ухраагүй байна. Хүлэгүгийн хүү Илхаан Абага-гийн үед Ромын пап, Францын хаантай цэрэг, улс төрийн талаар хамтран ажиллахад чиглэсэн оролдлогууд ихээхэн идэвхжсэн байна. 1274 онд тэрээр Пап Х Грегориуд Лион хот руу элчээ илгээж Египетийн эсрэг холбоо байгуулах, тухайлбал Египетийг Монголчууд ба Загалмайтны цэрэг хоер талаас дайрч эзлэхийг санал болгожээ. Пап энэхүү саналд нааштай хандаж байсан бөгөөд элч нарыг Франц ба Өрнөдийн бусад орон руу илгээж байв. Францын Луи хаан, Жеймс Арагон, Английн хоер ханхүү, хожим Сицилийн хаан болсон Шарль Анжу загалмайн дайнд бэлэн гэдгээ нотолж байв. Гэвч Венец, Сицил, Византийн хаад худалдааны эрх ашгаа урьдал болгож нэгэн зэрэг эхлэх гэж байсан загалмайн цэргийн дайралт хэрэгжээгүй юм. Энэ үеэр Францын Луи IX хаан нас нөгчиж улмаар Загалмайн дайны эрэн үе үндсэндээ шувтарсан байна.

Ил хаан Аргун гэхэд Өрнө зүгт 4 удаа элч төлөөлөгч илгээж байв. (10) 1289 онд Ил хаан Аргунаас Францын Гуа Филипп-д явуулсан захидалд Египетийн эсрэг хамсан довтлох саналыг нь зөвшөөрч Иерусалимыг танд өгье гэж санал болгож байв. Хожим Газан, Өлзийт нар ч Ромын пап, Францын Гуа Филипп-д захидал илгээж хамтран ажиллах талаар ярилцаж байсан боловч цэрэг, улс төрийн тодорхой тохиролцоонд хүрч чадаагүй билээ.

Хамтын ажиллагаа бүтээгүй өөр нэг шалтгаан бол бие биеэ бүрэн ойлгоогүйтэй холбоотой байжээ. Ромын пап ба Францын хаад цэрэг,улс төрийн хамтын ажиллагааны асуудлыг ямагт шашинтай холбож авч үзэж байв. Монголын Их хаад ба ялангуяа Илхаад христын шашинтныг өмгөөлөн хамгаална,худалдаачдыг ялгаварлан гадуурхахгүй гэж ямагт байр сууриа илэрхийлж байсан боловч Христын шашны тэргүүн нарт тэр нь хангалтгүй санагдаж байсан гэлтэй. Тэд монголчуудыг христын шашинд дагаар оруулахыг ихэд чухалчилж байв. Жишээлбэл,Каталаны христын лам Рэмон Лул гэгч Илхаадын үед Перс дэх монголчуудыг христын шашинд дагаар оруулах талаар идэвхтэй ажиллаж, өөрөө Персэд очиж, 'Татарууд ба Христын үзэл'ном бичиж,1285 онд Ромын пап,Францын Гуа Филипп хаантай уулзаж, Парисын Их Сургуульд 'монгол хэл заадаг болох', мөн монголчуудыг Парист явуулж хэл заах талаар ярилцаж байжээ. 1283 онд тэрээр '50 Татар бидний хэлийг сурч байгаа', тэднээс 30 хүн Христын шашинд орсон'гэж бичжээ.(11)

Ийнхүү монгол,францын элчийн харилцааны явцад цэргийн салбарт амжилт олоогүй ч чухам тэр үеэс эхлэн хоер орны хоорондын оюун санаа,соелын салбарын харилцаа үүсэн хөгжсөн юм.Ромын пап,Францын Луи IX хаан санаачилга гаргаж Өрнөдийнхөн Монголыг судалснаар тухайн үеийн Монголчуудын цэрэг,байлдааны сүр хүчийг таньж мэдэхээс гадна аль ч шашныг ялгаварлан гадуурхдаггүй монголчуудын оюун ухааны сүр хүчийг нээн илрүүлжээ.

ИШЛЭЛ,ЗҮҮЛТ

1. Дэвид хааны тухай домог - R.Grousset, Le Conquerant du Monde,Vie de Gengis-Khan,Albin Michel,1944,p.43-45
2. Matthew Paris,Chronica Major
3. M.Prawdin,The Mongol Empire, its rise and Legacy,London, 1940, p.248
4. Путешествия в восточные страны Плано Карпини и Рубрука,М.,1957,с.220-6.
5. Олон улс судлал,УБ,2002, х.40-46
6. Ж.Саундерс,Монголын байлдан дагуулал, Ж.Гэндэндарамын орчуулга,УБ,1992, х.110
7. Рашид-Ад-Дин,Сборник летописей,том 2,М,1960,с. 151
8. Путешествия в восточные страны Плано Карпини и Рубрука,М.,1957
9. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа,УБ,1995, х.153
- 10.мөн тэнд, х.154
- 11.Devin De Weeze,Mongolian Studies,Volume 1978&1979,Indiana University pp. 64-65